

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААГ ЕРӨНХИЙ СИСТЕМИЙН ОНОЛЫН ХАНДЛАГААР СУДЛАХ НЬ

П.Мягмардорж*

Дэлхийн II дайны дараа Олон улсын харилцаанд (ОУХ) тогтсон хоёр туйлт систем 1990-ээд оны эхэн үед задран унаж үзэл суртлаар хуваагдаад байсан өрнө дорнын эсрэгцэл дуусгавар болсноор олон тооны эрдэмтэн судлаачид XX зууны сүүлч, XXI зууны эхэн үеэс дэлхийн бодлого, олон улсын харилцаанд зарчмын томоохон өөрчлөлтөд орж байгааг тухай бичих болсон төдийгүй зарим нэг улс төр, олон улсын харилцааны судлаачид үндэстэн улс голлох байр суурьтай оролцох болсон Вестфалийн системийн суурь зарчмууд өөрчлөгдсөн өөр Вестфалийн үеийн ОУХ-ны систем (Вестфалийн эрин үе) задран, олон улсын харилцааны цоо шинэ эрин үе ирж буйг онцлон тэмдэглэх болсон байна.

Даяаршлын эрин үеийн янз бүрийн түвшний төрөл бүрийн хэлбэр бүхий ОУХ-ны үндсэн оролцогч нь (үндэстэн улс) өөрийн байр суурийг хадгалж үлдэхийн тулд гадаад бодлогынхоо зорилгыг (стратегийг) тодорхой болгож тэрхүү зорилгодоо хүрэх өөрийн арга хэрэгслийг (тактик) зөв сонгох шаардлага ялангуяа жижиг улсуудын хувьд урьд урьдаас илүүтэйгээр томоохон сорилт болон гарч ирж байна.

Өнөөгийн дэлхийн улс төрийн систем дэх даяаршлын үйл явц эрчээ аван гүнзгийрэхийн хэрээр аливаа улсын нийгэм улс төр, эдийн засаг, соёл иргэншлийн байдал нь гадаад орчин буюу ОУХ-ны системээс улам бүр хамаарах болсон тул гадаад бодлого, ОУХ-г системтэйгээр судлах шаардлага зайлшгүй бий болж байна. Иймд дэлхийн бодлого ба ОУХ-г судлахад системийн хандлагын ач холбогдолыг тодруулахад энэхүү ажлын гол зорилго оршино.

Орчин үеийн олон улсын харилцааны шинжлэх ухаанд системийн арга нэвтэрсэн нь:

Европын улсуудын шашин хоорондын 30 жилийн дайны төгсгөлд байгуулагдсан 1648 оны Вестфалийн энхийн гэрээгээр¹ орчин үеийн олон улсын харилцааны систем үүсч бий болсон бөгөөд энэхүү Вестфалийн гэрээгээр:

- Үндэсний эрх ашгийг дээдлэх зарчим
- Хүчний тэнцвэрийн зарчим

* ХИС-ийн багш, докторант

1. 1648 оны 5 сарын 15-нд Оснабрюкд Швед болон Протестант улсууд Ариун Ромын Эзэнт улстай, 1648 оны 10 сарын 24-нд Мюнстерт Франц улс Католик улсуудтай тус тус энх тайвны чуулга уулзалтыг хийж үр дүнд нь Вестфалийн энхийн гэрээг байгуулжээ.

- Үндэсний төрт улсыг хүлээн зөвшөөрөх зарчим
- Төрт улсын бүрэн эрхийн зарчим:

-Улс гүрний дотоод хэрэгт үл оролцох зарчим

-Европын улсуудын тэгш эрхийн зарчим

-Гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх зарчим

-Олон улсын харилцаанд яриа хэлэлцээр буюу дипломат ажиллагаа

болон Олон улсын эрх зүйг хэрэглэх зарчим гэх мэт өнөөгийн ОУХ-ны зарчмуудын үндэс суурь нь тавигдсан төдийгүй орчин үеийн ОУХ-ны анхдагч систем болох Вестфалийн систем бүрэлдэн тогтжээ².

Гэхдээ Вестфалийн систем гэдэг нь олон улсын гэрээ, хэлэлцээр болон зарчим хэм хэмжээнүүдийн цуглуулбар бус харин энэ бүхий л зүйлсийг нэгтгэн эмх цэгцэнд оруулан нэгэн бүхэл болгож буй систем³ хэмээн Оросын судлаач Марина Лебедева баталж буйн зэрэгцээ судлаачид Вестфалийн системийн задралын талаар бичихдээ уг системийн энэхүү онцлог талыг орхигдуулсанаар системийн юу нь өөрчлөгдөж, юу нь үгүй болж, юу шинээр бий болж эцэст нь ямар учраас энэ бүх өөрчлөлт явагдаж буйг ойлгоход төвөгтэй болно хэмээн тэрээр нотолжээ.

Вестфалийн энхийн гэрээ байгуулагдсанаар ХҮП зууны эхэн үед Европт үүсээд байсан нөхцөл байдал, тулгамдаж байсан асуудлыг шийдвэрлэсэн төдийгүй “ТӨРТ УЛСЫН БҮРЭН ЭРХИЙН ЗАРЧИМ”-аар дамжуулан цоо шинэ улс төрийн системийн эхлэлийг тавьж мөн энэ үеэс Европт харьцангуй тогтвортой төвлөрсөн засгийн газар, хүн ам, албан ёсны хил үүсч, улс орнуудын хооронд дипломат харилцааны эрх зүйн үндэс тавигдаж, чухамхүү энэ үеэс Европ нь дэлхийн бодлого, ОУХ-нд гол байр суурь бүхий бүс нутаг болсон юм.

Ийнхүү “Вестфалийн эрин үе” нь Европт эхлэлээ тавьж улмаар энэхүү шинэ улс төрийн систем нь цаашид улам бүр тэлэн хөгжиж 1713 оны Утрехтын гэрээгээр Европт хүчний тэнцвэр тогтож Наполеоны байлдан дагуулалын төгсгөлд хуралдсан 1815 оны Венийн чуулганаар олон талт дипломат ажилаагааг ОУХ-ны гол хэрэглүүр болгон XIX зууны дунд үеэс эхэлсэн аж үйлдвэрийн хувьсгалын 2 шатны үр дүнд Европын бус их гүрнүүд Вестфалийн системд багтах болж, Дэлхийн I дайны дараах Версаль-Вашингтоны системээр Вестфалийн систем нь де-юре Европоос халин Ази ба Алс Дорнодын бүс нутгийг хамарч, II дайны эцэст НҮБ байгуулагдаж олон улсын аюулгүй байдлыг хамгаалах нийт хүн төрөлхтөний дундын механизм үүссэн хэдий ч Ялта-Потсдамын буюу үзэл суртлаар хуваагдсан 2 туйлт систем тогтсон бол Хүйтэн дайны

2. *Фельдман Д. Барабанов О.* “Если Вестфаль и болен, то этот больной скорее жив, чем мёртв...” Журнал: “Международные процессы” Том 5, — № 3. 2007

3. *Марина Лебедева.* “ЧТО УГРОЖАЕТ ВЕСТФАЛЮ?”. Журнал: “Международные процессы” Текущий номер. Том 10, № 2(29). Май–август 2012

дараа, ялангуяа ХХI зуун гарснаар ДАЯАРШИЛ хэмээх хүчин зүйл ОУХ, дэлхийн бодлогыг тодорхойлогч гол хүчин зүйл болсноор Вестфалийн системийн суурь зарчмууд нийт хүн төрөлхтөнийг хамрах болж байна.

Гэхдээ өнөөдрийн байдлаар энэхүү дүгнэлтээс илүүтэйгээр ОУХ-ны өнөөгийн системийн ерөнхий дүр зураг, ялангуяа ОУХ-ны системийн цаашдын төлөв байдлыг тодруулах асуудал ОУХ-ны судалгааны гол судлагдахуун болж байна.

Вестфалийн системийн үр дүнд Үндэсний Төрт Улсын (nation state) улс төрийн бодлогыг дотоод, гадаад бодлого хэмээн хатуу ангилан авч үзэх практик тогтсон ба дотоод бодлого нь тухайн улсын бүрэн эрхийн асуудалд хамаардаг бол гадаад бодлого нь олон улсын харилцааны системээс шалтгаалж өөрчлөгддөг. Вестфалийн системээр олон улсын харилцааны системд оролцож буй оролцогчийн улс төрийн бодлогыг илүүтэй анхаарч үзсэнээс бус хүч чадавхи бүхий оролцогчийн эрх мэдлийн хэмжээ, дайн гарах, түүнийг зогсоох асуудал, системийн тогтвортой байдлын асуудал болон системийн туйлын асуудал гол асуудал биш байлаа.

Энэхүү байдал нь ХХ зууны дунд үе хүртэл үргэлжилсэн бол энэ үеэс ОУХ-ны ихэнх судлаачид Олон Улсын Байгууллага, Үндэсний Чөлөөлөх Хөдөлгөөн, Үндэстэн Дамнасан Корпорациуд зэрэг оролцогчдыг ОУХ-ны оролцогч хэмээн тооцох болж ОУХ-ны хэлбэр нь зөвхөн улс төрийн харилцаа биш эдийн засаг, нийгэм хүмүүнлэг, техник технологийн харилцаа болж байна.

Хэрэв орчин үеийн “олон улсын харилцааны систем” ба “Вестфалийн систем” хоёрыг ижил хэмээн үзэх аваас ОУХ-ны системийн судлах зүйлсийн талаарх маргаан: тухайлбал системийн тогтвортой байдал болон туйлт байдал, системд багтаж буй оролцогчдын хууль ёсны эрхийн ба системд тэргүүлэх байр суурь эзлэх зэрэг асуудлууд мөн л хоёрдугаарт тавигдаж байна. Гэвч орчин үеийн ОУХ-ны оролцогч байх бүхий л шалгуурыг хангаж буй үндэстэн улсууд олон улсын харилцаанд голлох нөлөө бүхий оролцогч хэвээр байгаа цагт дээрх асуудлууд ОУХ-ны судлах асуудалд томоохон байр суурь эзэлсээр байх болно.

Өнөөдөр улс орнууд хэрхэн системд тэргүүлэх байр суурь эзэлж ингэснээр дэлхийн улс төрийн хөгжлийн хандлагыг тодорхойлоход ямар үүрэг гүйцэтгэдэг тухай судлах зайлшгүй шаардлагатай⁴ хэмээн зарим судлаачид үзэж байна. Иймд ОУХ-ны хувирал өөрчлөлт, цаашдын чиг хандлагыг судлахын тулд ОУХ-г системийн түвшинд судлах зүй ёсны шаардлага хэвээр байсаар байна.

«Системийн анализ гэдэг нь явцуу утгаараа улс төр, цэрэг-стратег, нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн нарийн төвөгтэй бүтэц

4. Богатуров А.Д. “Лидерство и децентрализация в международных отношениях” . Журнал: “Международные процессы.” Том.4. № 3. 2006. С.5-15.

бүхий асуудалд анализ буюу дүн шинжилгээ хийх арга зүйн цогц бөгөөд өргөн утгаараа системийн анализ гэдэг нь аливаа зүйлийг судлах системийн хандлага»⁵ хэмээн Оросын судлаач А.Д. Богатуров системийн аргыг тодорхойлсон бол ОУХ-г системийн түвшинд судлах хандлага 1950-иад оны дундуур тухайн үеийн улс төр, олон улсын харилцааны шинжлэх ухаанд ноёрхох байр суурьтай байсан реализмын онолыг шүүмжилж байсан бихевиоризмын онолын сургууль (улс төрийн модернизм) гарч ирсэнээр тавигдсан билээ. Энэхүү ОУХ-ны онолын шинэ урсгал бий болоход тухайн үеийн ОУХ-ны орчин, бусад янз бүрийн хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

1. Шинжлэх ухаан технологийн хурдацтай хөгжил нь ОУХ-ны онолын болон эмпирик судалгаанд шинэ арга боломжуудыг авчирсан;
2. 1950-иад оны сүүлч үеийн ОУХ-ны хямралууд буюу хүйтэн дайны оргил үеийн ОУХ-ны нөхцөл байдал;
3. ОУХ-ны бүтцэд өөрчлөлт гарч дэлхийн хүчний тэнцвэрт байдал өөрчлөгдөн олон тооны тусгаар тогтносон улсууд бий болсноор хүчний шинэ төвүүд үүсч хоёр туйлаас олон туйлд шилжих эхлэл тавигдаж улс хоорондын хэлхээ холбоо улам гүнзгийрсэн;
4. Олон Улсын Байгууллагуудын үүрэг роль, тоо хэмжээ нэмэгдсэн;
5. АНУ-ын улс төрийн шинжлэх ухаанд шинэ шинэ эрдэмтэд гарч ирсэн явдал нь энэхүү онолын урсгал бий болоход нөлөөлсөн гол хүчин зүйлүүд болсон.

Энэ үед зарим эрдэмтэд бусад нийгмийн болон байгалийн шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, аргуудыг ашиглан олон улсын харилцаа, гадаад бодлогыг судлах болсон ба эдгээр эрдэмтдийг шинжлэх ухааны модернистууд буюу бихевиористууд хэмээн нэрлэж байсан бөгөөд гол төлөөлөгчид нь Куйнси Райт, Мортон Каплан, Карл Фридрих, Карл Дойч, Дэвид Сингер, Калеви Холсти, Эрнест Хаас, Жеймс Розенау нар билээ.⁶ Эдгээр эрдэмтэд дэлхийн бодлого, олон улсын харилцааг судлахдаа ерөнхий системийн онолыг авч ашигласан бол энэхүү онолыг анх шинжлэх ухаанд оруулж ирсэн хүнийг австри гаралтай АНУ-ын эрдэмтэн Людвиг фон Берталанфи хэмээн барууны эрдэмтэд баталдаг юм.

Нийгэм-улс төрийн шинжлэх ухаанд системийн онолыг ашиглахад Америкийн улс төр судлаач эрдэмтэд болох Т.Парсон, Д.Истон нарын судалгааны ажлууд чухал түлхэц үзүүлсэн байдаг. Канад гаралтай Америкийн улс төр судлаач эрдэмтэн Дэвид Истоны 1953 онд хэвлэгдсэн “Улс төрийн систем” хэмээх бүтээл голлох үүрэг гүйцэтгэсэн бол түүний энэхүү бүтээлд улс төрийн системийг “системийг бүрдүүлэгч дотоод элементүүдийнхээ байр байдлаас шалтгаалан системийн орчинтойгоо

5. Гайдес М.А. – Общая теория систем. (Системы и системный анализ). М., 2005, стр 14 .

6. С.А.Ланцов. В.А.Ачкасов. “Мировая политика и международные отношения” СПб., 2006, стр. 78

байнга “өөрийн хариултыг тулгаж” байдаг динамик хөдөлгөөн бүхий нэгэн бүхэл организм”⁷ гэж тодорхойлсон байна.

Харин ОУХ-ны салбарт анх удаа ерөнхий системийн онолыг авч ашигласан эрдэмтэн бол Сан Францискогийн их сургуулийн олон улсын харилцааны профессор Чарлез Армор Маклеланд⁸ бөгөөд тэрээр 1955 онд хэвлүүлсэн “Ерөнхий системийн онолыг ОУХ-нд авч ашиглах нь” хэмээх бүтээлдээ ОУХ-г янз бүрийн улсуудаас бүрэлдэж байдаг бие биенээсээ харилцан хамаарал бүхий элементүүдийн тогтолцоо (систем) гэж үзсэн байна.

Түүний энэхүү судалгааны ажлыг цааш нь М.Каплан, Ж.Розенау, Р.Роузкранц, Д.Сингер нар үргэлжлүүлсэн бөгөөд тэд “аливаа ОУХ-ны системийн зорилго нь системийн дотоод тогтвортой байдлыг хангахад оршино. ОУХ-ны систем нь бүтцийн хувьд тус тусдаа дэд систем, хэсгүүдэд хуваагдаж тэдгээр нь гадаад орчинтойгоо харилцахдаа нэг бүхэл болон хувирдаг”⁹ хэмээн үзэж байв.

Дээрхээс дүгнэн системийн онолын үндсэн ойлголтуудыг тодорхойлбол:

-Систем гэдэг нь бие биетэйгээ харилцан хамаарал бүхий элементүүдийн нэгдэл;¹⁰

-Элементүүд гэдэг нь системийг бүрдүүлэгч энгийн хэсгүүд буюу ерөнхий системийг бүрүүлж буй дэд системүүд;

-Системийн орчин гэдэг нь системийн харьцаж буй болон системд нөлөөлж буй гол хүчин зүйл;

-Системийн бүтэц гэдэг нь системийн янз бүрийн түвшинд тусгалаа олж байдаг ээдрээ бүхий хэд хэдэн төлөв байдалтай байдаг. Үүнд дараах төлвүүд багтана. Үүнд:

а) систем дэх элементүүдийн харьцаа;

б) систем дэх элементүүдийг зохион байгуулах чадвар;

в) элементүүдийн төлөө оршин тогтнож буй системийн шаардлагаас гарч буй хязгаарлалт болон албадлагын үйл ажиллагааны цогц;

-Системийн үүрэг гэдэг нь системийн бүтцэд багтаж байгаа элементүүдийн хооронд тогтсон тодорхой шинжийн харилцаа буюу тогтвортой байдлыг хадгалах зорилгоор системийн орчны өөрчлөлтөд хариу үзүүлж буй үйлдэл¹¹ хэмээн үзэж болох бөгөөд ОХУ-ны системийг дараах байдлаар тодорхойлж болох юм.

7. Easton D. “The Political System: An Inquiry into the State of Political Science.” New York., 1953, p. 135.

8. Robert L. Pfaltzgraft. “Politics and the International System”. Lippincott., 1972, p. 111.

9. С.А.Ланцов, В.А.Ачкасов. “Мировая политика и международные отношения” СПб., 2006, стр. 79

10. Bertalanffy L. үан. “General Systems Theory”. 1968, p. 5.

11. Мунтян М.А. “Основы теории международных отношений” Учебное пособие. М., Изд-во МАБиУ., 2006, стр.82

“Олон улсын харилцааны систем гэдэг нь нь ОУХ-ны түүхийн тодорхой үед өөрийн гэсэн онцлог бүхий орчинтой олон улсын харилцааны бүтэц тогтож байдаг ба энэхүү түүхэн тодорхой үед янз бүрийн оролцогчдын (гол нь nation state буюу үндэсний улс) хооронд тогтсон бие биедээ харилцан нөлөөлөгч төрөл бүрийн харилцааны хэлхээ холбоос бүхий нэгдмэл цогц бөгөөд олон улсын харилцааны системийн зорилго нь тухайн системийн тогтвортой байдлыг хадгалахад оршдог”.

Бихевиористууд мөн олон улсын харилцааны систем болон дотоод улс төрийн систем хоорондын уялдаа холбоог сайтар судалсан байна. Тухайлбал 1960-аад онд Ж.Розенау энэ талын судалгааг хийсэн бөгөөд дотоод улс төрийн системийн оролцогчийн үйл ажиллагаа нь олон улсын харилцааны системд нөлөөлж мөн системийн оролцогчийн үйл ажиллагаа нь дотоод улс төрийн системд нөлөөлдөг болохыг баталсан байна.¹²

Аливаа улсын гадаад бодлого нь гадаад хүчин зүйлс гэхээсээ илүүтэй дотоод хүчин зүйлсээр тодорхойлогддог гэж Ж.Розенау үзээд үүний зэрэгцээ бусад улс болон олон улсын харилцааны систем нь дотоод бодлогод нөлөөлдөг болохыг баталсан. Үүндээ тулгуурлан тэрээр дотоод бодлого нь гадаад бодлогынхоо зорилтыг тодорхойлно гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Ж.Розенау гадаад бодлогод нөлөөлдөг 5 гол хүчин зүйлийг гаргаж ирсэн.¹³ Үүнд:

1. Хувийн хүчин зүйл (шийдвэр гаргагчийн хувийн зан чанар);
2. Үүрэг ролийн хүчин зүйл (шийдвэр гаргагчийн нийгэмд эзэлж буй байр суурь);
3. Засгийн газрын хүчин зүйл (ЗГ-ын бүтэц, түүний гадаад бодлогыг үзэх үзэл);
4. Нийгмийн хүчин зүйл (нийгмийн үнэт зүйлс, үндэсний нэгдмэл байдал, эдийн засгийн хүчин зүйл гэх мэт);
5. Системийн хүчин зүйл (Гадаад орчин, олон улсын системийн гадаад бодлогод нөлөөлөх хүчин зүйл);

Дээрхээс үзэхэд бихевиористууд олон улсын харилцааны асуудлуудад дүн шинжилгээ хийхдээ гадаад бодлогын шийдвэр гаргагч янз бүрийн хувь хүмүүс, бүлгийн үүрэг ролийг судлахыг гол болгож байсан бөгөөд нөгөөтэйгүүр олон улсын харилцааны системийг дотоод улс төрийн системтэй холбон тайлбарлаж байсан явдал нь энэ салбар ухааныг бие даасан шинжлэх ухааны түвшинд хүргэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэжээ.

Бихевиоризмын онолын сургуулийн томоохон төлөөлөгч К.Дойч 1968

12. С.А.Ланцов. В.А.Ачкасов. “Мировая политика имеедународные отношения” СПб., 2006, стр. 80

13. Мөн тэнд

онд хэвлүүлсэн “Олон улсын харилцааг задлан шинжлэх нь”¹⁴ хэмээх бүтээлдээ “олон улсын харилцааны цорын ганц оролцогч нь үндэсний улс хэмээн үздэг реалистуудын үе өнгөрч, янз бүрийн улс орнуудын харилцан хамаарал улам бүр ихэсч улсуудын бүлэглэл болон олон улсын байгууллагын үүрэг нэмэгдэж байна. Ингэснээр олон улсын харилцааны шинжлэх ухааны судалгаанд улс орон гол байх суурь эзлэхээ больж харин тэдгээрийн хоорондын харилцаа, хамтын ажиллагаа гол боллоо” гэжээ.

Дээрх судалгаанаас дүгнэхэд бихевиоризмын онолын сургууль нь олон улсын харилцааны үндсэн ойлголтуудаас илүүтэй судалгааны арга, арга зүйн асуудалд гол анхаарлаа хандуулсан бөгөөд тухайн үеийн олон улсын харилцааны нөхцөл байдлыг дараах байдлаар дүгнэжээ:

1. Орчин үед тээвэр, харилцаа холбоо хурдацтайгаар хөгжсөнөөр улс орнууд улам бүр ойртон нягтарч байна.
2. Улсуудын хоорондын харилцаанд эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагаа гол үүрэг гүйцэтгэж байна.
3. Өнөөгийн олон улсын харилцааны хөгжлийн гол хандлага нь харилцан хамаарал болж байна.

Дүгнэлт

1648 оны Вестфалийн энхийн гэрээгээр тавигдсан орчин үеийн олон улсын харилцааны систем 300 гаруй жилийг өнгөрүүлж XX зууны дунд үетэй золгосон ба энэ үеэс эхлэн олон улсын харилцаанд томоохон өөрчлөлтүүд бий болж Вестфалийн системийн суурь зарчмууд ямар нэгэн байдлаар өөрчлөгдөж, үндэстэн улсаас гадна шинэ оролцогчид дэлхийн бодлого ба олон улсын харилцаанд асар их нөлөөтэй болж байгаа хэдий ч Вестфалийн системийг задарч байна хэмээн шууд дүгнэлт хийх нөхцөл байдал цаг хугацааны хувьд ч тэр системийн агуулгын хувьд ч үүсээгүй байна. Учир нь олон улсын харилцааны системийн ихэнх суурь зарчмууд, системийн орчин, бүтэц, системийн үндсэн үүрэг ч өөрчлөгдөөгүй байна.

ОУХ-ны үйл явц нь байнгын динамик өөрчлөлтөд оршиж байдаг нийгмийн үзэгдэл бөгөөд энэхүү өөрчлөлт нь түүхэн тодорхой үед өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий бүтэц, орчин элементүүд мөн оролцогчидтой байдаг. Өнөөдөр дэлхийн бодлогыг асар хурдацтай өөрчилж буй даяаршил хэмээх нийгмийн үзэгдэл олон улсын харилцаанд мөн адил хүчтэй нөлөөлж байна. Ийнхүү хурдацтайгаар өөрчлөгдөж буй ОУХ-ны мөн чанарыг судлахад түүний оролцогчид хэн байх, хэлбэр нь ямар байхаас үл шалтгаалан системийн хандлагаар судлах нь цаг хугацааны хувьд ч, онолын хувьд ч зөв сонголт байх болов уу. Өөрөөр хэлбэл ерөнхий системийн онолын судалгаа нь дан ганц ОУХ-ны системийн орчинг бус

14. Karl Wolfgang Deutsch. “The analysis of international relations” Prentice-Hall., 1968

мөн дотоод улс төрийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийдэг байдал нь энхүү хандлагын найдвартай байдлыг давхар илтгэж байгаа явдал юм.

Эцэст нь олон улсын харилцааны нэрт судлаач Стэнли Хоффманы¹⁵ “Системийн судалгаа нь олон улсын харилцаанд дүн шинжилгээ хийхэд яах аргагүй үр дүнтэй онолын суурь судалгаа болж чадахын зэрэгцээ олон улсын харилцаа, гадаад бодлогын онолын хоорондын ялгааг тодруулах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй эдгээр онолын цаашдын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг”¹⁶ гэсэн дүгнэлтийг нэмье.

Ашигласан номзүй

I. Орос хэл дээр:

1. Богатуров А.Д. “Лидерство и децентрализация в международных отношениях” . Журнал: Международные процессы. Т.4. № 3. 2006
2. Гайдес М.А. – Общая теория систем. (Системы и системный анализ). Винница: Глобус-пресс., 2005
3. Зонова Т.В. Вестфальская система / Т.В. Зонова // Вестник МГИМО – Университета. – 2008 - № 1
4. С.А.Ланцов. В.А.Ачкасов. “Мировая политика и международные отношения” СПб., 2006
5. М.Лебедева. “Что угрожает вестфалю?” Журнал: «Международные процессы» Текущий номер. Том 10, № 2(29). Май–август 2012
6. Мунтян М.А. Основы теории международных отношений. Учебное пособие. М., Изд-во МАБиУ, 2006
7. Я.Пляйс. “Трансформация систем международных отношений в хх веке” Финансовая академия при Правительстве РФ.
8. Токаев К.К. Трансформация системы международных отношений в начале XXI в. и приоритеты внешней политики Республики Казахстан. журнал «Казахстан-Спектр» №2-2007
9. А.В. Торкунов.” Современные международные отношения” Учебник. 1999
10. Цыганков П.А.” Теория международных отношений” Учеб. пособие. -М., Гардарики, 2003
11. Фельдман Д., Барабанов О. “Если Вестфаль и болен, то этот больной скорее жив, чем мёртв...” Журнал: Международные процессы. 2007
12. С.В.Юрченко. Трансформация современной системы международных отношений: основные тенденции. Таврического национального университета им. В.И. Вернадского.

15. АНУ-ын Харвардын ИС-ийн профессор.

16. Hoffmann S. Theorie et relations internationales. // Revue française de science politique. Vol.XI. 1961, p. 428.

II. Бусад хэлээр:

1. Bertalanffy L. Үан. “General Systems Theory”. 1968
2. Easton D. “The Political System” 1953
3. Hqffmann S. “Theorie et relations intemationale”s. // Revue frain;aise de science politique. Yol.XI. 1961
4. Geoffrey L. Herrera, “Technology and International Transformation: The Railroad, the Atom Bomb, and the Politics of Technological Change”. Albany: State University of New York Press, 2006
5. Immanuel Wallerstein, “The Modern World-System: Capitalist Agriculture and the Origins of the European World-Economy in the Sixteenth Century”. New York: Academic Press, 1976
6. Karl Wolfgang Deutsch. “ The analysis of international relations” Prentice-Hall, 1968
7. Luk Yan Langenhoye. “Multilateralism 2.0: The transformation of international relations” 2011
8. Peter Sutch. Juanita Elias. “International relations: THE BASICS”. Routledge. 2007
9. Richard Rosecrance. “ Power and International Relations: The Rise of China and Its Effects”. International Studies Perspectives (2006) yol 7,
10. Robert L. Pfaltzgraff.” Politics and the International System”. 1972